

НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Я.Байгалмаагийн Солонгос улсын хүүхэд хамгааллын
үйл ажиллагаатай танилцах айлчлал

ИЛТГЭХ ХУУДАС

2013 оны 11 сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Зорилго

Солонгос улсын хүүхэд хамгааллын тогтолцоо, хууль эрх зүйн нөхцөл, хүүхэд хамгааллын байгууллагууд тэдгээрийн үйл ажиллагаа болон үзүүлж буй үйлчилгээний арга зүй, аргачлалыг судлах 2013 оны 10 сарын 20-ноос 27-ны өдрүүдэд Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Буяндалай, ХТҮГ-ын МСМГ-ын дарга Ч. Эрдэнэбат, Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч н.Баясах, Нийслэлийн Боловсролын газрын сургалт, арга зүйн хэлтсийн дарга Жаргалантуул, ХТҮГ-ын харьяа ХГБХ-ийн Өнөр бүл төвийн дэд захирал Д. Цагаанжанар, ХТҮГ-ын харьяа ХХХТ-ийн нийгмийн ажилтан А. Цэнджаргал, Гүүд Нейборс ОУБ-ын Монгол дахь салбарын захирал Со Тэ Вон, Гүүд Нейборс ОУБ-ын Монгол дахь салбарын менежер н.Бадамгарав, н.Галсайхан, н.Алтансоёмбо, н.Нэргүй нарын хамт томилолтоор ажилаж туршлага судалсан болно.

Хусан хотын Халамж үйлчилгээний төв

Хусан хот нь 500.0 гаруй хүн амтай бөгөөд хотын төсвөөр “Нийгмийн халамжийн үйлчилгээний цогцолбор”-ын барилгыг барьж үйл ажиллагааг нь чиглүүлэх эрхийг ТББ-аар гүйцэтгүүлж байна. Тус төвийн төсвийн 60 хувийг улсаас 40 хувийг төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхээр гэрээлсэн байгууллага буюу Гүүд Нейборс ОУБ санхүүжүүлэх зарчмаар ажиллаж байна.

National Child Protection Agency /Хүүхэд хамгааллын үндэсний газар/

БНСУ-ын ЭМНХЯ-ны харьяанд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг тус улсын хэмжээнд 51 салбар бүхий төрийн захиргааны байгууллага.

Тус байгууллагын үндсэн чиг үүрэг нь БНСУ-ын Үндсэн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн 45-р зүйлд заасан эрх үүргийг хэрэгжүүлж БНСУ-д хамгаалал шаардлагатай байгаа болон хамгаалагдвал зохих хүүхэд, тэдгээрийн эрх, ашиг сонирхолыг дээдлэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллахад оршиж байна. БНСУ-д хүүхдийн эрхийн асуудал нь тус улсын “Хүний эрхийн үндэсний комисс”-ийн түвшний асуудал байхаар эрх зүйн зохицуулалт хийгдсэн.



Хүүхэд хамгааллын 51 салбар байгууллагатай.

/Хүүхэд хамгааллын хуулийн 45-р зүйлд тусгасан байдаг./

Дэргэдээ яаралтай тусламжийн утас/24 цаг/

/Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22-р зүйлд тусгасан байдаг. /

Асрамж халамжийн цогцолбор

1. Ахмад настнуудын ажил, амралтын үйлчилгээ
2. Өсвөр үеийнхний чөлөөт цагийн үйлчилгээ
3. Хүүхдийн тоглоомын өрөө/ зээлийн үйлчилгээ
4. Номын сангийн өрөө
5. ХБХ-д үзүүлэх үйлчилгээ
6. Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээ
7. Кейс үйлчилгээ/ хүнд нөхцөл
8. Сургалтын үйлчилгээ
9. Явуулын үйлчилгээ
10. Ажил мэргэжлийн үйлчлэх үйлчилгээ

Кейвон аймгийн Канвонду хотын Асрамжийн газар

◆ **Хүүхэд түр хамгаалах үйлчилгээг үзүүлдэг. /3-6 сар/**

◆ **21 хүүхэдтэй, 15 ажилтантай.**

Үйлчилгээний дараалал:

1. Хүүхэд хүлээн авах
2. Сэтгэл зүйн оношлогоо
3. НБҮ хийх
4. Хоол тэжээл, эрүүл мэндийн үйлчилгээ
5. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
6. Гэр бүлд зөвлөгөө өгөх
7. Гэр бүлд нь эргэн нэгтгэх
8. Садан төрлийн асрамжинд шилжүүлэх
9. Асрамжийн байгууллага руу шилжүүлэх

Түр асрамжлах төв

Тус төв нь 2006 онд байгуулагдсан. Асрамж, халамжийн үйлчилгээ, сэтгэл зүйн оношлогоо, зөвлөгөө, гэрт нь буцаах, асрамжийн газар өгөх, хүүхдийн эрхийн зөрчлийн илрүүлэлтийг хамгааллын үндсэн асуудлын нэг болгож чадсан бөгөөд илрүүлэлтийн дийлэнх хувийг ЭМНХЯ-ны харъяа яаралтай тусламжийн 129 дугаар /МОНW Call center/, мөн Үндэсний хүүхэд хамгааллын газарт харъяалагдах 1577-1391 /CPA Hotline/, гэсэн дугаар дээр 24 цагийн турш хүлээн авч кейс үүсгэж 72 цагийн дотор зохих арга хэмжээг авч ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.

Үйл ажиллагааны үндсэн зарчим

- ◆ Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах,
- ◆ Эрх мэдлийн оновчтой хуваарилалтыг бүрдүүлэх,
- ◆ Салбарын үйл ажиллагааг бодлогоор хангаж хөндлөнгөөс үл оролцох,
- ◆ Хяналт үнэлгээг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгох,
- ◆ Төлөвлөгөөт ажлыг ягштал баримталж тухай бүр хяналт, үнэлгээг хийж байх,
- ◆ Асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх,
- ◆ Ажилтнуудын стрессыг бууруулах, дэмжлэг үзүүлэх,
- ◆ Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хамтын **удирлагыг хэрэгжүүлэх,**
- ◆ Төвлөрсөн халамжаас зайлсхийж хүүхдэд хүрэх үр өгөөжийг нэмэгдүүлэх,

- ◆ Хүний нөөцөө чадавхижуулж хамгаалал, хөгжлийн үйлчилгээг нэг хүүхэд, нэг бүлд хүргэхэд гол анхааралаа хандуулж удирдлагын нүсэр бүтцээс татгалзах,
- ◆ Олон улсын болон ижил төстэй байгууллагуудтай идэвхитэй хамтын ажиллагаатай байх,
- ◆ Хүүхдийн эрхийг хамгаалах үйлсэд ашиглах хөрөнгийн эх үүсвэрийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагааны менежментийг бий болгоход төвлөрөн ажиллаж байна.

Хүүхдийн эрхтэй холбоотой батлан гаргасан шийдвэр, баримт бичгүүдийн ангилал

- Парламентаас гаргасан
- Ерөнхийлөгчөөс гаргасан
- Засгийн газар, сайдын эрх хэмжээний
- Захиргааны байгууллагаас гаргасан

Хууль зүйн суурь баримт бичгүүд

БНСУ-ын Үндсэн хууль, Хүүхэд хамгааллын хууль /Child welfare Act/ болон бусад эрхийн акт байна.

Судалгаагаар хүүхдийн эрхийн хүчирхийлэлийн 80 гаруй хувь нь тус улсын хувьд гэр бүлээс үүдэлтэй байгаа талаар статистик мэдээллээс харгалзан гэр бүл чиглэсэн ганцаарчилсан ба группын сургалтыг өргөн хэмжээнд зохион байгуулахад анхаарч байна.

Нийт 51 салбарын зөвхөн 3-ынх нь үйл ажиллагаа, санхүүжилтийг ҮХХГазар бие даан хэрэгжүүлж байгаа бол үлдсэн 47 салбарын үйл ажиллагааг 3-5 жилийн гэрээгээр ТББ-дад хариуцуулан төсвийн 60 хувийг төрөөс 40 хувийг үйл ажиллагаагаа явуулж байгаа ТББ хариуцаж байна. Good Neighbors ОУБ нь дээрх 51 салбараас 21 салбарын үйл ажиллагаатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хариуцан ажиллаж байна.

Нийт 51 салбарын зөвхөн 3-ынх нь үйл ажиллагаа, санхүүжилтийг ҮХХГазар бие даан хэрэгжүүлж байгаа бол үлдсэн 47 салбарын үйл ажиллагааг 3-5 жилийн гэрээгээр ТББ-дад хариуцуулан төсвийн 60 хувийг төрөөс 40 хувийг үйл ажиллагаагаа явуулж байгаа ТББ хариуцаж байна. Good Neighbors ОУБ нь дээрх 51 салбараас 21 салбарын үйл ажиллагаатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хариуцан ажиллаж байна.

Асрамжийн газарт үйлдэгдэж буй хүүхдийн хүчирхийллийн асуудал байгаа тул асрамжийн газрын дэргэд зөвлөх багийг ажиллуулдаг бөгөөд Зөвлөх багийн үндсэн үүрэгт хяналт үнэлгээг хийх, удирдлагын хандлагыг өөрчлөх зэрэг чиглэл багтаж байна.

- ◆ Хүүхэд түр хамгаалах үйлчилгээг үзүүлдэг. /3-6 сар/
- ◆ 21 хүүхэдтэй, 15 ажилтантай.

Кейвон аймгийн Канвонду хотын Асрамжийн газар

Үйлчилгээний дараалал:

1. Хүүхэд хүлээн авах
2. Сэтгэл зүйн оношлогоо
3. НБҮ хийх
4. Хоол тэжээл, эрүүл мэндийн үйлчилгээ
5. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх
6. Гэр бүлд зөвлөгөө өгөх
7. Гэр бүлд нь эргэн нэгтгэх
8. Садан төрлийн асрамжинд шилжүүлэх
9. Асрамжийн байгууллага руу шилжүүлэх

Асрамжийн талаар төрөөс баримтлах бодлого

Төвлөрсөн халамжаас аль болох зайлсхийх, асрамжит гэр бүлийн тогтолцоог /Foster familia / дэмжих, хүүхдэд хүрэх дэмжлэг тусалцааны үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулж ажилладаг.

ЭМНХЯ-ны харъяа Хүний нөөцийг чадавхижуулах институт

Нийгмийн хамгааллын байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах, арга зүйгээр хангах үндэсн чиг үүрэг бүхий байгууллага юм. 2001 оноос Хүүхдийн эсрэг хүчирхийлэлийн талаарх сургалтын үйл ажиллагаа идэвхижүүлж байна.

Сургалтын 3 төрөл

Нийгмийн хамгааллын байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах, арга зүйгээр хангах үндэсн чиг үүрэг бүхий байгууллага юм. 2001 оноос Хүүхдийн эсрэг хүчирхийлэлийн талаарх сургалтын үйл ажиллагаа идэвхижүүлж байна.

Хүүхэдтэй ажиллаж буй нийгмийн ажилтнуудын сургалт

Хүүхдийн байгууллагад анх орж буй нийт албан тушаалтан 13 нэр төрлийн 103 цагийн суурь сургалтанд заавал хамруулж сертификат олгож албан тушаалд томилж, суурь сургалтын дараа мэргэжүүлэх сургалтыг үргэлжлүүлдэг.

Чадавхижуулах сургалтын төлөвлөгөөг нэг жилээр гаргаж ажиллахын зэрэгцээ шаардлагатай ном товхимол, гарын авлага, олон нийтэд түгээх мэдээллийн сан бүрдүүлж, сургалтын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж байна. Масс руу чиглэсэн нөлөөллийн шинжтэй хандлага өөрчлөх сургалтанд түлхүү анхаарч ажилладаг.

Багшлах боловсон хүчний шалгуур

Хүүхэд хамгааллын чиглэлийн эрдэмтэн, дээд сургуулийн багш, ҮХХГ-т зөвлөхөөр ажиллаж буйгаа ажилтан, эсвэл түүнтэй дүйцэхүйц мэргэжилтэн /хуульч, өмгөөлөгч, хүүхдийн эмч/

Сургалтын төрөл

- Хүүхэд, өсвөр насныханд зориулсан сургалт
- 2012 оноос эцэг, эхтэй зохион байгуулах сургалт
- Хүүхэдтэй ажиллаж буй албан хаагчдад зориулсан мэдээлэл, сургалт
- Гарын авлага, таниулах материалаар хангах
- Цахим сургалт
- Урьдчилсан сэргийлэх, олон нийтийг хамарсан сургалт

Төв Good Neighbors ОУБ

Тус байгууллага нь 23 жилийн өмнө БНСУ-ын иргэдийн санаачлагаар байгуулагдсан. Нийгмийн хамгаалал, иргэдэд нийгмийн хөгжлийн боловсрол олгох, хүүхдийн эрийн асуудлаар дагнан үйл ажиллагаа явуулдаг дэлхийн 29 оронд салбартай НҮБ-д зөвлөх эрх бүхий томоохон ТББ юм.

Одоогоор БНСУ-ын хэмжээнд нийгмийн халамжийн болон хүүхдийн эрхийн асуудлаар төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэн ажилаж байна. 2005 оноос Монгол улсад салбар нээгдсэн. Хүүхэд эрх хамгааллын чиглэлээр БНСУ-ын хэмжээний үйл ажиллагааны 25 гаруй хувийг дангаар эрхлэн явуулдаг. Хүүхдийн эрхийн хүчирхийлэлийн эсрэг явуулах үйл ажиллагаагаа идэвхижүүлж байна.

Нийгмийн халамжийн нийгэмлэг

- ◆ 1952 онд байгуулагдсан 61 жилийн түүхтэй.
- ◆ Төр засагтай уялдан иргэний нийгэм, ТББ-ыг дэмжиж ажилладаг.
- ◆ Улсын төвсийн 1/3 нь халамжийн үйлчилгээнд зарцуулагддаг.

Халамжийн үйлчилгээ нь:



- ◆ Өндөр настан
- ◆ Эмэгтэйчүүд
- ◆ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд

Үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг

- Төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжиж ажиллахад чиглэгддэг,
- Өндөр настан, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээ, туслалцаа,
- Нийгмийн хамгаалал, халамжийн чиглэлээр төрөөс баримтлах бодлогод иргэдийн дуу хоолойг хүргэх, олон улсын түвшинд үйл ажиллагаагаа явуулах

Тус улсад нэг жилийн улсын төсвийн 3/1 хувийг халамж, нийгмийн хамгаалалд зориулдаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэд сурч боловсрох, тэгш хамгаалуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн, 1989 оноос эрүүл мэндийн даатгалын шинэ тогтоолцоонд шилжүүлэн, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ажилтнуудын эрхийг хамгаалах, 1999 оноос амьжиргааны доод түвшний амьдралтай иргэдэд тусламж

үзүүлэх хуулийг батлуулсан зэргээр шууд болон шууд бус байдлаар хүүхдийн эрхийг хамгаалах талаар үйл ажиллагаагаа явуулж ирсэн.

Нийгмийн халамжийн нийгэмлэг нь нийгмийн хамгааллын ажилтнуудын нийгэмлэгийг бидний туслалцаатайгаар Монгол улсад байгуулах, улмаар тус нийгэмлэгийг ОУ-ын нийгмийн хамгааллын нийгэмлэгт гишүүнээр элсүүлж хамтарсан үйл ажиллагаагаа өргөн цар хүрээтэй явуулах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Кёнгй аймаг Су Вон хотын ҮХХГ-ын харъяа агентлаг

Тус аймагт нийт 10 харъяа агентлаг байдаг бөгөөд энэ агентлаг нь зүүн өмнөд хэсгийг хариуцсан.

Төрөөс хүүхдийн эрхийг хамгаалах агентлагыг байгуулж ажиллах нөхцлийг бүрдүүлж ТББ-тай гэрээ байгуулан үйл ажиллагааг нь хариуцан ажиллуулдаг. Агентлаг нь ҮХХГ-т харъяалагдахын зэрэгцээ орон нутгийн засаг захиргааны байгууллагадаа захирагдан ажил хэргээ явуулдаг.

Хүүхэд хамгааллын төв

- ◆ Хүүхэд хамгааллын өөрийн харъяа 10 төвтэй.
- ◆ 31 сумыг хамарсан.

яаралтай дуудлагын утас-24 цаг

Дуудлагын дагуу

- ◆ Хүнд кейст 12 цагийн дотор
- ◆ Бусад тохиолдолд 72 цагийн дотор шийдвэрлэдэг.

Үзүүлдэг үйлчилгээ:

- ◆ Зөвлөгөө өгөх
- ◆ Кейс нээн хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх /Эмчилгээ, Зөвлөгөө, дэмжлэг тусламж болон хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй ажиллах/
- Сургалт сурталчилгаа
- Захиргааны хэлтэс гэсэн хэлтсийн зохион байгуулалттай ажиллуулдаг
- Дуудлагаар ирсэн хүүхэд нэг бүрт цахим болон цаасаар кейс нээж коджуулж байна.
- Хүүхэдтэй холбоотой кейс мэдээллийг зөвхөн шүүхийн шийдвэрээр ашиглах боломж нээгддэг.

- Хүүхдэд үзүүлэх үйлчилгээг дээд газраас батласан үйлчилгээний дараалалын дагуу үзүүлэхийн зэрэгцээ хүүхдийн эсрэг хүчирхийлэлийг тогтоох check list бөглөж хүүхдийн амь насанд аюултай нөхцөлд байгаа бол эцэг, эх бусад байгууллагын зөвшөөрөлгүйгээр хүүхдийг 72цагийн хугацаатай тусгаарлах эрхтэй байдаг.

Гүүд нэйборс ОУБ-ын зөвлөгөө өгөх төв



03-18 насны хүүхэд /

Үйлчилгээ:

- ◆ Зургаар
- ◆ Тоглоомоор
- ◆ Хөдөлгөөн
- ◆ Хөгжим
- ◆ Сэтгэл зүйн оношлогоо

Зөвлөгөөний хугацаа 45-60 минут

7 хоногт 1 удаа,/3,4 сар үргэлжилнэ./

Сөүл хотын ажлын байр хариуцсан хэлтэс

- ◆ 3 хэлтэс, 22 ажилтантай.

Үйлчилгээ:

- ◆ Ажилгүй иргэдэд мэргэжлийн үнэмлэх олгох
- ◆ Сургалт зохион байгуулах
- ◆ Ажил хайгч, ажил олгогчийг холбон зуучлах
- ◆ Зөвлөгөө өгөх

Ажилгүйдлийн түвшин 2% байна.

Үр дүн

БНСУ-ын хүүхдийн эрх хамгааллын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааг газар дээр нь танилцах, цаашид үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг бүрдүүлсэн.